

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Баянхутаг сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/016/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Б.Хуланхатан Утас: 99008827 Цахим хаяг: khulankhatanb@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 508

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Баянхутаг сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэм зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- ✓ Төсвийн төвлөрүүлэн захирагч нь сумын ИТХ-аар батлагдсан үйл ажиллагааны орлогыг 1,673.2 мянган төгрөг, газрын төлбөрийн орлогыг 993.8 мянган төгрөгөөр, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтийг 26,490.9 мянган төгрөгөөр тус тус дутуу бүрдүүлсэн.
- ✓ Санхүүжих эх үүсвэрийг орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлийг 1,451.8 мянган төгрөгөөр, ОНХС-ийн үлдэгдлийг 2,572.6 мянган төгрөгөөр дутуу төлөвлөсөн.
- ✓ ХХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдэл 116,407.3 мянган төгрөгийг барагдуулах арга хэмжээ аваагүй.

- ✓ ЗДТГ нь 23,371.2 мянган төгрөгөөр багаж техник хэрэгсэл худалдан авахад тендер зарлаагүй байна.

Энэ нь дараах хууль тогтоомжийг зөрчсөн байна. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;" 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх;" 6.4.-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:" 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;"
- ✓ Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана",
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;"
- ✓ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралт "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.4.5-д "зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх" 7.3-т "Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгах бөгөөд хөнгөлөлттэй зээлийг зориулалтын бусаар зарцуулсан, зээлийн гэрээнд заасан заалтыг зөрчсөн зээлдэгчийн зээлийн гэрээг цуцалж, зээлийг Сангийн дансанд буцаан төвлөрүүлэх ажиллагааг зохион байгуулна" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 19 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,564,625.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,039,276.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 525,349.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөж, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,932,201.3 мянган төгрөг буюу 75.3 хувьтай байна.

Аудитын гол асуудал

Баянхутаг сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 708,529.3 мянган төгрөгийн 13 алдаа, зөрчил илэрч 535,568.4 мянган төгрөгийн 9 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 27,395.6 мянган төгрөгийн

зөрчилд 2 албан шаардлага, 145,565.2 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн болно.

Орон нутгийн төсөвт 374,940.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 500,970.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 126,030.9 мянган төгрөгөөр буюу 133.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Зургаадугаар хуралдаанаар сумын Засаг даргын 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг 90.1 хувь буюу “Үр дүнтэй” гэж дүгнэсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангаас 525,349.7 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 14 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 256,865.3 мянган төгрөгийн 13 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын байр барих ажлын санхүүжилтийн эрх тавигдаагүй тул хийгдээгүй байна.

Сумын төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөх, батлагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		744,471.99	1,059,538.89
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	461,914.97	737,907.76
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	203,746.22	195,738.32
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	60,775.8	73,857.81
5	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	18,035.0	52,035.0
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,265,836.8	2,150,495.62
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,265,836.8	2,150,495.62
8	1.2.2.02 Биет хөрөнгө		2,013,850.8	1,898,509.62
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	251,986.0	251,986.00
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		3,010,308.79	3,210,034.51
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		-	87,877.46
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		-	87,877.46
13	2.1.1.03 Өглөг		-	87,877.46
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,010,308.79	3,122,157.05
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		3,010,308.79	3,122,157.05
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		335,715.86	335,715.9
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		2,392,980.46	2,504,828.72
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		281,612.48	281,612.48
19	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		3,010,308.79	3,210,034.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		2,783,884.32	2,212,153.89
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		453,904.21	495,261.91
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		304,432.13	308,660.25
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		304,432.13	308,660.25
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		44,811.75	34,392.53
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		104,660.33	152,209.13
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	626,104.54	1,716,891.98
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		-	1,270,983.06
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,703,875.58	-
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,611,996.58	1,838,922.44
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		1,611,996.58	1,838,922.44
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,575,376.27	1,798,577.42
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		666,529.79	897,908.54
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		77,810.06	102,348.83
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		290,461.93	396,006.91
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		77,438.43	33,758.63
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		-	335.25
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		40,517.63	74,016.36
19	1.1.2.01.1.07 Томиллт, зочны зардал		19,028.00	16,390.00
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		221,799.66	59,026.01
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		181,790.77	218,786.89
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		36,620.31	40,345.02
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,171,887.74	373,231.45
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		565,476.99	261,383.19
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(565,476.99)	(261,383.19)
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		606,410.75	111,848.26

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,403,980.05		2,403,980.05
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(82.0)		(82.0)
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,403,898.05		2,403,898.05
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	606,410.75		606,410.75
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,010,308.79		3,010,308.79
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,010,308.79		3,010,308.79
7	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,010,308.79		3,010,308.79
8	1.7 Тайлант үеийн үр дүн	111,848.26		111,848.26
9	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,122,157.05		3,122,157.05

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,202,947.14	2,222,253.06
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	453,904.21	495,261.91
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	304,432.13	308,660.25
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	44,811.75	34,392.53
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	104,660.33	152,209.13
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,502.91	11,582
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	5,862.52	6,012.23
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	89,294.9	134,614.9
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,667.36	1,726,991.14
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	48,667.36	24,785.28
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	1,270,983.06
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	431,222.8
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,700,375.58	-
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,474,920.18	1,655,109.42
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,474,920.18	1,655,109.42
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,439,889.87	1,609,885.68
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	666,529.79	886,427.89
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,810.06	102,589.03
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	379,248.64	397,699.41
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	61,437.41	27,213.37
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	2,143.9	1,178
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	47,357.03	71,311.16
23	1.1.1.2.01.1.07 Томилт, зочны зардал	19,028	13,600
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	112,388.79	52,940.2
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	73,946.25	56,926.63
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,030.31	45,223.74
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	728,026.96	567,143.63
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	588,456.89	291,150.84
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	588,456.89	291,150.84
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	588,456.89	291,150.84
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(588,456.89)	(291,150.84)
32	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	139,570.07	275,992.79
33	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	322,344.9	461,914.97
34	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	461,914.97	737,907.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,017,119.80	3,635,554.39
11	3.1.01.1.1 Татварын орлого	367,440.00	495,261.91
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	300,500.00	308,660.25
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	300,500.00	308,660.25
	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал		
110001	болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	220,000.00	225,968.38
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	64,000.00	62,465.17
110003	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	13,400.00	16,940.70
110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	3,100.00	3,286.00
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	3,760.00	34,392.53
113001	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	3,000.00	3,672.53
113002	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	760.00	720.00
113004	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	-	30,000.00
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	63,180.00	152,209.13
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,500.00	11,582.00
	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	1,500.00	6,582.00
118009	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5,000.00	5,000.00
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	7,000.00	6,012.23
118101	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	7,000.00	6,012.23
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	49,680.00	134,614.90
118202	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	49,680.00	134,614.90
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	3,649,679.80	3,140,292.47
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	51,000.00	20,285.28
120003	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	6,500.00	4,394.00
120004	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	43,000.00	13,509.13
120010	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	500.00	1,067.20
120009	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	1,000.00	1,314.95
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	3,167,457.00	2,688,784.40
122003	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	1,260,149.20	1,260,149.20
122005	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	1,907,307.80	1,428,635.20
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	431,222.80	431,222.80
	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого		
123002	орлого	431,222.80	431,222.80
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,564,625.90	3,633,055.13
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,911,807.80	3,376,189.79
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,863,485.90	1,635,347.98
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	968,250.70	886,427.89
	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	396,342.50	388,049.35
210102	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	417,085.70	371,445.30
210103	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	32,760.00	27,395.97
210104	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	75,100.30	57,703.11
210105	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	46,962.20	41,834.16
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,031.30	102,589.03
210201	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	82,301.40	76,302.15
210202	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	9,682.50	8,985.22
210203	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	4,841.20	4,497.72
210204	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	4,841.20	2,636.92
210205	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	19,365.00	10,167.02
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	423,387.40	397,699.41
210301	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	66,052.40	51,466.23
210302	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	332,570.40	331,570.18
210303	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	24,764.60	14,663.00

2104	3.1.01.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	39,912.40	27,213.37
210401	3.1.01.2.1.1.4.01	Бичиг хэрэг	4,910.90	3,729.50
210402	3.1.01.2.1.1.4.02	Тээвэр, шатахуун	25,294.40	17,150.40
210403	3.1.01.2.1.1.4.03	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,035.20	5,284.30
210405	3.1.01.2.1.1.4.05	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,117.00	145.62
210406	3.1.01.2.1.1.4.06	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,554.90	903.55
2105	3.1.01.2.1.1.5	Нормативт зардал	4,807.10	1,178.00
210503	3.1.01.2.1.1.5.03	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,807.10	1,178.00
2106	3.1.01.2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	119,558.90	105,596.66
210601	3.1.01.2.1.1.6.01	Багаж, техник, хэрэгсэл	39,615.80	37,350.50
210603	3.1.01.2.1.1.6.03	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943.10	-
210604	3.1.01.2.1.1.6.04	Урсгал засвар	79,000.00	68,246.16
2107	3.1.01.2.1.1.7	Томилолт, зочны зардал	21,089.00	13,600.00
210702	3.1.01.2.1.1.7.02	Дотоод албан томилолт	21,089.00	13,600.00
2108	3.1.01.2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	73,068.80	47,142.06
210801	3.1.01.2.1.1.8.01	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,751.90	44,158.82
210802	3.1.01.2.1.1.8.02	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	961.70	-
210803	3.1.01.2.1.1.8.03	Даатгалын үйлчилгээ	1,014.30	1,014.30
210804	3.1.01.2.1.1.8.04	Тээврийн хэрэгслийн татвар	536.40	508.91
210805	3.1.01.2.1.1.8.05	Тээврийн хэрэгслийн оношлогоо	245.60	187.00
210806	3.1.01.2.1.1.8.06	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,595.40	997.80
210807	3.1.01.2.1.1.8.07	Газрын төлбөр	963.50	275.22
2109	3.1.01.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	92,380.30	53,901.56
210901	3.1.01.2.1.1.9.01	Бараа үйлчилгээний бусад зардал	73,539.40	49,631.66
210902	3.1.01.2.1.1.9.02	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,840.90	4,269.90
213	3.1.01.2.1.4	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,321.90	1,740,841.82
2131	3.1.01.2.1.4.1	Засгийн газрын урсгал шилжүүлэг	10,000.00	1,710,849.80
213101	3.1.01.2.1.4.1.01	Засгийн газрын дотоод шилжүүлэг	10,000.00	9,996.00
213103	3.1.01.2.1.4.1.03	Төсвийн санхүүжилт	-	1,700,853.80
2132	3.1.01.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	38,321.90	29,992.02
213207	3.1.01.2.1.4.2.06	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,740.40	25,155.00
213209	3.1.01.2.1.4.2.08	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,581.50	4,837.02
22	3.1.01.2.2	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	525,349.70	256,865.34
223001	3.1.01.2.2.4	Бусад хөрөнгө	525,349.70	256,865.34
23	3.1.01.2.3	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	127,468.40	-
230001	3.1.01.2.3.1	Эргэж төлөгдөх зээл	127,468.40	-
8	3.1.01	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,452,493.90	2,499.26
9	3.1	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(1,452,493.90)	(2,499.26)
7	3	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(1,452,493.90)	(2,499.26)
4	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	461,838.32
5	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	736,556.17

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,833.86
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,833.86
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	10,833.86
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	10,833.86
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	10,833.86
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,350.86
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,483.00
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,798.14
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	5,798.14
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,798.14
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,798.14
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,798.14
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	5,035.72
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(5,035.72)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(5,035.72)

Гурав. Аудитын илрүүлэлт: Баянхутаг сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 6 байгууллага, 1 төрийн сан, 2 тусгай сан нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллагын санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан байна.

Аймаг дахь Төрийн аудитын газар Засаг даргын тамгын газар, Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд, “Платиниум прогресс аудит” ХХК Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн.

3.1 Тус сумын харьяа орон нутгийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар:

Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 154,989.1 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илрүүлснээс 131,617.9 мянган төгрөгийн 7 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 23,371.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

Иргэдийн төлөөлөгчдийн хурал

- 1. Санхүүгийн тайланд орон нутгийн төсвөөс санхүүжих урсгал үйл ажиллагааны санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлгийг 10,504.2 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг 1,000.0 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасныг санхүүгийн тайланд залруулсан.*

Засаг даргын тамгын газар

- 1. Санхүүгийн тайланд орон нутгийн төсвөөс санхүүжих урсгал үйл ажиллагааны санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлгийг 35,361.5 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг 3,500.0 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасныг санхүүгийн тайланд залруулсан.*
- 2. Машин тоног төхөөрөмж дансанд ухаалаг дэлгэцний үнийг программ суулгасан хөлс, хөгжүүлэлтийн 7,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж орлого авсныг зардалд хааж залруулсан.*
- 3. ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэгдсэн 34,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод авч залруулсан.*
- 4. Тайлант хугацааны элэгдлийн зардлыг 8,220.0 мянган төгрөгөөр илүү тооцож тайлагнасныг санхүүгийн тайланд бууруулж залруулсан.*
- 5. Тайланд онд 23,371.2 мянган төгрөгийн багаж техник хэрэгсэл худалдан авахад цахим тендер зарлаагүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сан

- 1. Мөнгөн гүйлгээний тайланд сумын малын тоо толгойн албан татварын орлогын 26,485.0 мянган төгрөгийг ОНХС-ийн санхүүжилтээр тайлагнасныг урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр бүртгэж залруулсан.*

Хоршоо хөгжүүлэх сан

- 1. Зээлийн хүүгийн авлагын 5,547.2 мянган төгрөгийг санхүүгийн тайланд зээлийн авлагаар бүртгээснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.*

3.2 Тус сумын харьяа улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 66,374.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 63,592.7 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 1,270.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,511.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

Эрүүл мэндийн төв

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

Соёлын төв

- 1. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 15,138.2 мянган төгрөгөөр дутуу тооцож тайлагнасныг санхүүгийн тайланд зардлыг бууруулж залруулсан.*
- 2. Уран бүтээл хийх зардлаас номын баяр, урлагын наадам, танин мэдэхүйн тэмцээний шагналд 1,511.3 мянган төгрөгийг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.*

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Ерөнхий боловсролын сургууль

- 1. Тайлант онд 2 ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 1,270.5 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон байна.*

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

Хүүхдийн цэцэрлэг

- 1. Шатахууны үлдэгдлийг зөрүүтэй тоолж, санхүүгийн тайланд 795.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн алдааг аудитын явцад залруулсан.*
- 2. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 47,658.9 мянган төгрөгийн барилгын засварыг данс бүртгэлд тусгалгүй орхигдуулсныг залруулсан.*

3.3 Сумын засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Баянхутаг сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 403,950.5 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайланд залрууллаа. Үүнд:

- 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд замд яваа мөнгө 6,338.2 мянган төгрөгийг тусгаагүй.*
- 2. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд зээлийн хүүгийн авлагыг 5,547.2 мянган төгрөг, ажиллагсадтай холбогдсон өглөгийг 131.6 мянган төгрөг, засгийн газрын санг 334,537.5 мянган төгрөгөөр, нэгтгэсэн үр дүнгийн тайланд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 49,395.9 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 8,000.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй нэгтгэсэн байна.*

Аудитаар нийт 149,589.6 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч, 4,024.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 145,565.2 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

3.3.1 Төлбөрийн акт

Байхгүй.

3.3.2 Албан шаардлага

1. *Тайлант онд төсвийн тодотгол 1 удаа хийсэн боловч урьд оны үлдээдлээс санхүүжих эх үүсвэрийг орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдээдлийг 1,451.8 мянган төгрөгөөр, ОНХС-ийн үлдээдлийг 2,572.6 мянган төгрөгөөр тус тус дутуу төлөвлөсөн байна.*

3.3.3 Зөвлөмж

1. *Үйл ажиллагааны орлогыг 1,673.2 мянган төгрөг, газрын төлбөрийн орлогыг 993.8 мянган төгрөгөөр, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтийг 26,490.9 мянган төгрөгөөр тус тус дутуу бүрдүүлсэн байна.*

Өгсөн зөвлөмж: *Сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлж байх.*

2. *ХХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдэл 116,407.3 мянган төгрөгийг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.*

Өгсөн зөвлөмж: *Хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авах.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ	1	11,504.2			1	11,504.2	1	11,504.2				
ЗДТГ	4	88,081.5	1	34,000.0	3	54,081.5	4	88,081.5				
ХХС	1	5,547.2			1	5,547.2	1	5,547.2				
ОНХС	1	26,485.0			1	26,485.0	1	26,485.0				
ОН-ын дүн	7	131,617.9	1	34,000.0	6	97,617.9	7	131,617.9	-	-	-	-
Соёлын төв	1	15,138.3			1	15,138.3	1	15,138.3				
СӨБ	2	48,454.4			2	48,454.4	2	48,454.4				
УТ-ын дүн	3	63,592.7	-	-	3	63,592.7	3	63,592.7	-	-	-	-
Дархан ЗД	2	403,950.5	1	6,338.2	1	397,612.3	2	403,950.5				
ТТЗ-ын дүн	2	403,950.5	1	6,338.2	1	397,612.3	2	403,950.5				
Нийт дүн	12	599,161.1	2	40,338.2	10	558,822.9	12	599,161.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан		Хууль, хяналтын байгууллагад		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
	-	-	-	-									
ОНБ-ын дүн	-	-	-	-	-	-							
Соёл	1	1,511.3			1	1,511.3							
ЕБС	1	1,270.5	1	1,270.5	-								
УТБ-ын дүн	2	2,781.8	1	1,270.5	1	1,511.3	-	-	-	-	-	-	-
Дархан ЗД	3	149,589.6			1	4,024.4	2	145,565.2					
ТТЗ-ын дүн	3	149,589.6	-	-	1	4,024.4	2	145,565.2	-	-	-	-	-
Нийт дүн	5	152,371.4	1	1,270.5	2	5,535.7	2	145,565.2	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	-	-					-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЗДТГ	1	23,371.2					1	23,371.2
ОНБ-ын дүн	1	23,371.2	-	-			1	23,371.2
		-						
УТБ-ын дүн	-	-	-	-	-	-	-	-
	-	-					-	-
ТТЗ-ын дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	23,371.2	-	-			1	23,371.2

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	6	4	2		4			
2	ОНТС	2		2					
3	ОНӨҮГ								
4	ТТЗ	1	1				1		
	НИЙТ	9	5	4		4	1		



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 24

Дугаар 256-А2370452

ХЭА-2026/016/НА-СТА-ТТЗ

Чингис хот

Г Зөрчлийг таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баянхутаг сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг дарга нь орон нутгийн ерөнхий орлогын дансны урьд оны үлдэгдлээс 1,451,833.00 (нэг сая дөрвөн зуун тавин нэгэн мянга найман зуун гучин гурван) төгрөг, ОНХС-ын үлдэгдэл 2,572,590.00 (хоёр сая таван зуун далан хоёр мянга таван зуун ерэн) төгрөгийг тус тус бүрэн төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;" 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх;" 6.4.-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:" 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Д.Байгалмаа даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Б.ХУЛАНХАТАН